



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар АИНО

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хот тохижилтын газрын үйл ажиллагаанд иргэний гаргасан гомдлын дагуу шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Э.Энхцэцэг	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Лувсанчимэд	Аудит, Дотоод хяналтын хэлтсийн дотоод хяналтын мэргэжилтэн
	Т.Туул	Аудит, Дотоод хяналтын хэлтсийн дотоод хяналтын мэргэжилтэн
	Д.Сүхбат	Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Э.Уянга	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Гомдол мэдээллийг шалгах удирдамж батлуулж, дүнг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР